

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ
ОРШИХ АЙРГИЙН ЭНГЭРИЙН АЛТНЫ
ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч

Хэрэгжилтийг гаргасан:

Хүдэр-Эрдэнэ ХХК-ийн уул уурхайн зөвлөх

Ч.Энхбаяр

Хүдэр-Эрдэнэ ХХК-ийн геологич

Д.Буриад

ГАРЧИГ

ОРШИЛ.....	3
НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	4
1.1 Уурхайн байршил, газарзүйн тогтоц	4
1.2 Цаг уур, уур амьсгал	5
1.3 Гадаргын усан сүлжээ, газрын доорх ус	5
1.4 Хөрсний төлөв байдал	5
1.5 Ургамлан нөмрөг.....	6
1.6 Амьтны аймаг.....	6
1.7 Геологийн тогтоц	7
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ	
ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1 Уурхайн ашиглалтаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүд.....	8
2.2 Болзошгүй аюул, осол.....	8
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН	
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	11
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	11
3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	23
ДӨРӨВ. 2024 оны үзүүлэлтүүд	26

ОРШИЛ

Баруун Баруун-Урт, Айргийн Энгэрийн алтны шороон орд нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах бөгөөд Налайх хотоос зүүн урагш 45 км-т Жанчивлангийн рашаан сувиллаас баруун урагш 20 км-т, Багахангай тосгоноос зүүн хойш 20 км-т, Улаанбаатар хотоос зүүн урагш 90 км-т оршино.

“Хүдэр-Эрдэнэ” ХХК нь Баруун баруун уртын алтны шороон ордыг ашиглах MV-000131 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлөөр олгогдсон нийт 443.0 га талбайтай.

Уурхайн олборлолтын ажлыг Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль болон холбогдох бусад хууль, журам, зааврын дагуу жил бүрийн “Уулын ажлын төлөвлөгөө” болон “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг” боловсруулан батлуулж түүний дагуу уулын ажил болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байна.

“Баруун Баруун-Урт, Айргийн Энгэрийн алтны үүсмэл ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г 2021 онд “ЕАСС” ХХК-иар шинэчлэн хийлгэсэн бөгөөд дээрх үнэлгээнд заасан зөвлөмж болон төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Айрагийн доод энгэрийн үүсмэл ордын В-14, 15, С-9, 10 блокууд, овоолгын 8, 9, 14, 15 талбайд ашиглалт явуулж, 234.1 мян.м³ олборлон, 107.7 мян.м³ элс угааж, химийн цэврээр 5.98кг алт олборлохоор төлөвлөснөөс энэ онд В,С блокуудыг бүрэн, Овоолго-8,9-с 70.0 мян.м³, Овоолго 14, 15-с 37.0 мян.м³ эфель олборлон шигшиж, нийт химийн цэврээр 3.62 кг алт олборлосон болно. Төлөвлөгөө тасалдсан шалтгаан нь “Усны газар”-аас ус ашиглуулах дүгнэлт хүлээгдэж, энэ оны 7-р сарын 10 хүртэл зөвхөн хайрга олборлолт, шигшилтийн үйл ажиллагаа явагдсан бөгөөд 7-р сарын 15-наас элс угааж эхэлсэнтэй холбоотой. Мөн овоолго-14, 15 хэсэгт ажил гүйцэтгэх гэрээт туслан гүйцэтгэгчээр ажиллаж байсан компаний үйл ажиллагаа 8-р сарын 20-нд бүрэн зогссон зэрэг шалтгаанаас ажлын үзүүлэлт буурсан болно.

“Хүдэр-Эрдэнэ” ХХК нь уул уурхайн зориулалтын тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон бөгөөд бульдозер САТ-D6, экскаватор САТ-320В, БНХАУ-д үйлдвэрлэсэн өөрөө буулгагч 2 машин болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна. Тайлант онд уурхайн олборлолтын ажилд нийт 25 хүн ажилласан.

Айргийн энгэрийн дээд доод хэсгийн алтны шороон ордын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны

менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулав.

НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1. Уурхайн байршил, газарзүйн тогтоц

Баруун Баруун-Урт, Айргийн Энгэрийн алтны шороон орд нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших бөгөөд Налайх хотоос зүүн урагш 45 км-т Жанчивлангийн рашаан сувиллаас баруун урагш 20 км-т, Багахангай тосгоноос зүүн хойш 20 км-т байрлана. Нийслэл Улаанбаатараас зүүн урагш 90 км-т оршиж 65 км хатуу хучилттай замаар, 15 км шороон замаар холбогдоно. Улаанбаатар-Сайншандын төмөр зам хайгуул хийсэн талбайн баруун талаар 13 км зайд өнгөрөх ба ойролцоох өртөө нь Цагаан хяр болно. Төв аймгийн Сэргэлэн сум нь физик газарзүйн байрлалын хувьд Хэнтийн нурууны өмнөд хажуугаас салбарласан нам өндөрлөг уулс, тал хээрийн бүсийн ерөнхий шинж тэмдгийг хадгалсан хэсэгт далайн түвшнээс дээш 1520-1740 м-ийн өндөрт оршино. Ордын ойролцоо орших хамгийн өндөр цэгүүд нь Адуун чулуут уул (1670.0) Урт овоот (1653.0), Майхан толгой (1691.8) Бага хангай уул (1742.1) зэрэг өндөрлөгүүд юм.



Төсөл хэрэгжих талбайн орчны төлөв байдлын байрзүйн зураг (Эх М 1:1000000)

1.2 Цаг уур, уур амьсгал

Цаг уурын хувьд Монгол оронд ноёлох эх газрын эрс, тэс уур амьсгал зонхилох бөгөөд энэ нь хоног, улирлын агаарын температурын хэлбэлзэл ихтэй, жилд унах тунадасны хувиарлалт жигд бус, хуурай, сэрүүн байдгаараа тайлбарлагдана.

Агаарын температур зун 7-р сард $+38^{\circ}\text{C}$, өвөл 1-р сард -47°C хүртэл хэлбэлздэг, дундаж температур $-3,5^{\circ}$, хамгийн дулаан 7-р сард агаарын дундаж температур $+17,1^{\circ}\text{C}$, хамгийн хүйтэн 1-р сард $-27,4^{\circ}\text{C}$ байна.

Жилд дунджаар 240-250 мм тунадас унах ба ихэнх нь 7, 8-сард, багахан нь өвлийн улиралд унах ба агаарын харьцангуй чийгшилт 70-75% байдаг. Ихэвчлэн 5-р сарын дунд үе хүртэл үргэлжлэн цасан бүрхүүл тогтдог.

Салхины жилийн дундаж хурд 2.3 м/сек ба ноёлох чиг нь хойд ба баруун хойд зүг юм. Жилийн ихэнх өдрүүдэд салхитай, салхины хурд ихэнх улиралд 15-20 м/сек-д хүрнэ.

1.3 Гадаргын усан сүлжээ, газрын доорх ус

Бүс нутгийн хэмжээнд тогтмол урсгалтай гол цөөн, Зүүн уртын гол, Буурал хангайн горхи, Баруун уртын горхи зэрэг булаг шандтай. Районы нутаг дэвсгэрт олон жилийн цэвдэг хөлдүү алаг цоог тархсан, уул толгодын бэл хормойгоор намгархаг учир зарим хэсэгтээ дулааны улиралд бэрхшээл тохиолдоно.

Тус орд газар орчимд байнгын урсацтай гол, горхи болон нуур цөөрөм зэрэг гадаргын усан сүлжээ байхгүй тул уурхайн техникийн усан хангамжийн асуудал нилээд хүндрэлтэй байдаг.

Угаах төхөөрөмжийн усны хэрэгцээг хур тунадасны усыг хуримтлуулан гүний худгийн усаар сэлбэх замаар эргэлтийн усан сан байгуулж ханган ажиллаж байна.

Хэрэгцээт усныхаа 80%-ийг эргэлтийн усаар, 20%-ийг цэвэр усаар сэлбэн хангаж, нуурын усны түвшинг барьж байхаар төлөвлөсөн.

Гадаргуугийн усан сүлжээ багатай учир ундны болон ахуйн хэрэгцээний усыг худаг гаргаж хангадаг бөгөөд худгуудын ундарга их биш хязгаарлагдмал байдгаас алт олборлолтыг явуулахдаа хэд хэдэн худгаас усан сан хуримтлуулан ашигласан усаа шүүн цэвэршүүлж эргүүлэн ашигладаг.

1.4 Хөрсний төлөв байдал

MV-000131 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбай нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутгийн зүүн урд талд байрлалтай бөгөөд Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өргөрөгийн бүсшилийн Хар хүрэн ба хүрэн

хөрсний дэд бүсийн Мааньтын 4-р тойргийн нутгийг хамарна. (Монгол улсын үндэсний атлас, 2009)

Алт олборлолт явагдаж байгаа газарт дараах хөрсүүд голлон тархсан байна. Үүнд:

Уулын хар хүрэн хөрс: Энэ хөрс уулархаг газраар голлон тогтворжсон байх бөгөөд хөрсний үржил шимийн түвшингээр дундаж хэмжээнд байх ба уулын хээрийн ургамлан нөмрөгтэй, гадаргын хэрчигдэл ихтэй, хад, хайрга чулуу ихтэй байх тул бэлчээрийн эдэлбэрийн зориулалтаар байна.

Сайр чулуурхаг болон сайргархаг хар хүрэн хөрс /толгодын/: Энэ хөрс ашиглалтын талбайд нам уулс тэдгээрийн бэл хормойн хэсгээр болон толгодорхог гүвээрхэг гадаргаар тогтворжих бөгөөд үетэн, алаг өвс нилээд холилдсон хээрийн ургамалшил дор голлон тогтворжих бөгөөд тархалтын доод хил нь толгодын бэл хормойн буюу геоморфологийн хилээр голын хөндийн хөрснөөс тод зааглагдана.

Нугархаг хар хүрэн хөрс: Энэ хөрс уулс хоорондох голын хөндийн хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт нутгийн чийгсэг ургамал болох нугын ургамал бүхий үетэн, улалжилт бүлгэмдэл давамгайлах ба тухайн хөрс үржил шимийн түвшин өндөртэй.

Хар хүрэн хөрс: Энэ хөрс уулс хоорондох өргөн, нарийн хөндийн гүвээрхэг болон тэгшивтэр хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт тал хээрийн ургамал болох үетэн-алаг өвст бүлгэмдэл давамгайлах ба тухайн хөрс үржил шимийн түвшин өндөртэй байна.

1.5 Ургамлан нөмрөг

Уурхайн эдэлбэр нь ургамал газарзүйн мужлалаар Дагуур Монголын хээрийн провинци, Дорнод Монголын хээрийн тойрог, Югзэрийн районд хамрагдана.

Энд ургамлан бүрхэвчийн хувьд 50-60% бүрхэцтэй, арви харьцангуй сийрэг ургамлан нөмрөгтэй. Мөн бусад ургамал-газарзүйн тойрогтой харьцуулбал зүйлийн бүрдлийн хувьд нийт 39 овог, 104 төрөлд хамаарах 175 зүйл ургамал бүртгэгдсэн байна.

Тус орд газар нь уурхайн ашиглалт явуулж эхлэхээс өмнө бэлчээрийн эдэлбэр байсан. Уурхай орчмын нутаг дэвсгэр нь ерөнхийдөө чулуурхаг хээрийн шинжийг илтгэсэн хялганат хээрийн бэлчээрийн хэв шинжтэй хааяа нэг шингэн дэрс энд тэнд ургасан байна.

1.6 Амьтны аймаг

Тус нутагт тал хээрийн амьтдаас зурам, оготно, хулгана, туулай, алаг даага зэрэг мэргэчид, үнэг, хярс, өмхий хүрэн зэрэг махчин амьтад элбэг тохиолдохоос гадна төрөл бүрийн жигүүртэн шувууд суурин ба нүүдлийн байдлаар амьдардаг.

1.7 Геологийн тогтоц

Тус районд протерозой-доод кембрийн/PR-E1/ болон девон /D/-ын галавын тунамал, хувирмал чулуулгууд болох шаварлаг занар, элсэн чулуулаг тархжээ.

Баруун баруун-уртын голын хөндийд дээрх хурдас чулуулгууд нь орчин цагийн аллюв-пролювийн гаралтай сэвсгэр хурдсаар хучигдсан ба түүний доод хэсгээр алтны хуримтлал үүссэн байна.

Алтны шороон ордыг үүсгэгч дөрөвдөгчийн хурдас нь элсэнцэр хайрга ба шавранцар үе давхаргуудаас бүрдэнэ. Түүний дундаж зузаан нь 1.8-2.2м. Алт агуулсан аллюв-пролювийн хурдас цайвар саарал, дээд хэсэгтээ боровтор саарал өнгөтэй том жижиг чулуулгийн хэмхдэс агуулна.

Алтны мөхлөгүүд нь ул чулуу болох занарын дээд хэсгээр өгөршиж хэмхэрсэн ан цавуудаар доод нэвчиж шингэсэн байдаг. Хөрсний зузаан нь 0.80-1.0м, элсний зузаан 1.0-1.6м, ордын нийт урт 3 км, дундаж өргөн нь 50м, тус орд нь нөөцийн зэргээрээ 3-р группэд багтдаг жижиг орд юм.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Уурхайн ашиглалтаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүд

2.1.1 Хөрсөн бүрхэвч

Уурхайн хөрс хуулалт, элс, хайрга тээвэрлэлт, овоолго зэрэг технологийн үйл ажиллагаа нь газрын хөрс, агаар орчин, гадаргын болон гүний ус, ордын нөөц, ургамал амьтны аймаг, оршин суугчдын эрүүл ахуй зэрэг байгаль орчны бүхий л тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлдэг. Айрагийн энгэрийн дээд доод хэсгийн алтны уурхайн хувьд эдгээрээс хамгийн их нөлөөлөлд өртөж байгаа нь хөрсөн бүрхэвч, газрын хэвлий юм.

Дотоод овоолго хийх, уурхайн малталтанд өртсөн газарт нөхөн дүүргэлт хийж тэгшлэх, хэлбэршүүлэн засч хиймэл нуур байгуулах зэргээр эвдэрсэн газрыг нөхөн сэргээсэн.

2.1.2 Агаар орчин

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас агаар орчин бохирдохоос гадна уурхайн малталтанд өртсөн газар болон хөрсний овоолгын гадаргуугаас хийсэх тоос шороо орчны агаарыг бохирдуулдаг. Иймд уурхайн малталтанд өртсөн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн.

2.1.3 Усан орчин

Уурхай орчимд байнгын урсацтай гол, горхи болон нуур цөөрөм зэрэг гадаргын усан сүлжээ байхгүй. Иймд угаах төхөөрөмжийн усны хэрэгцээг хур тунадасны усыг хуримтлуулан гүний худгийн усаар сэлбэх замаар эргэлтийн усан сан байгуулан ажиллаж байна.

Уурхайн ашиглалтын улмаас гадаргын усанд бараг нөлөөлөхгүй харин гүний усанд бага зэрэг нөлөөлөл үзүүлнэ. Иймд технологид хэрэглэсэн усаа шүүн тунгааж дахин ашигласаар ирсэн. Шинээр гүнийн цооног 1-ийг өрөмдүүлж, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж байна.

2.2 Болзошгүй аюул, осол

2.2.1 Техникийн аюулгүй ажиллагаа

Уул уурхайн үйлдвэрлэлд аюул, ослын талаар судалгаа, дүгнэлт хийж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөл болон аваарь ослоос урьдчилан сэргийлэх талаар техник зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Иймд жил бүр аваарь устгах төлөвлөгөөг боловсруулан батлуулж дагаж мөрдөж байна.

Ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл, техникийн бүрэн бус байдал зэргээс гадна байгалийн гэнэтийн аюул ослоос шалтгаалж уурхайд болзошгүй аюул осол учирч болно. Иймд ашиглалт явуулахдаа Монгол улсад мөрдөгдөж буй хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хууль тогтоомж, дүрэм журам буюу “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Баяжуулах тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны нэгдсэн заавар”, “Үйлдвэр аж ахуйн байгууллагын галын аюулгүй ажиллагааны дүрэм”, “Үйлдвэрийн газрын аюулгүй ажиллагааны дүрэм” зэргийг өөрийн уурхайн онцлог байдалд тохируулан мөрдөхөөс гадна ажил мэргэжил тус бүрийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллалаа.

Үйлдвэрийн аваарь осол, саатал, гэмтэл бүр нь эдийн засгийн болон ажиллагсдын эрүүл мэнд, амь насанд хохирол учруулах, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх аюултай. Иймд ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангаж ажилладаг. “Форум ланд” сургалтын төвтэй гэрээ байгуулан ажлын байрны аюулгүй ажиллагааны сургалтыг хамтран 3 дахь жилдээ зохион байгуулсан болно.

Байгалийн гэнэтийн аюул осолд гал түймэр, аянга цахилгаан, үер усны аюул, газар хөдлөлт зэрэг ордог. Эдгээр нь хүний үйл ажиллагаанаас хамааралгүйгээр гэнэт учирч болох аюул учраас үүнээс урьдчилан сэргийлэх, тухайн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, анхны тусламж үзүүлэх талаар сургалт семинар зохион байгуулж ажиллав.

2.2.2 Гал түймэр

Уурхайн ашиглалт явуулахдаа “Үйлдвэр аж ахуйн байгууллагын галын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллахаас гадна, хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд салхи, шуурга ихтэй үед ил задгай газарт гал гаргахаас болгоомжилж ажиллаа.

Иймд гал түймрээс урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авч, гал түймрийг унтраах багаж хэрэгслээр бүрэн хангасан.

2.2.3 Аянга, цахилгаан

Зуны улиралд аянга цахилгаантай өдрүүдэд уурхайн техник хэрэгсэл, ажилчдын хөдөлмөрлөх нөхцөл түр саатаж улмаар аюул тохиолдох магадлалтай.

Иймд дуу цахилгаантай бороотой үед металл хийц бүхий тоног төхөөрөмж болон байгууламжаар дамжин ажиллагсад аянга цахилгааны осолд өртөхөөс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Шаардлагатай тохиолдолд уурхайн ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авч ажиллаа.

2.2.4 Үер

Баруун Баруун-Урт, Айргийн Энгэрийн алтны шороон орд нь хуурай сайруудыг дагаж ашиглалт явуулдаг тул үер усны нөлөөлөлд өртөх өндөр эрсдэлтэй юм.

Тус уурхай нь усны нөөц бага учраас хур тунадасны усыг хуримтлуулж элс угаахад ашигладаг тул хур тунадас элбэг байх нь уурхайн үйл ажиллагаанд ашигтай байна. Гэсэн хэдий ч зун, намрын улиралд үргэлжилсэн их устай бороо орох нь уурхайн талбайд их хэмжээний үерийн ус хуримтлагдаж уурхайн үйл ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүйг анхаарч, суваг шуудуу татсан болно.

Иймд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайг тойруулан үерийн хамгаалалтын далан, шуудуу татсан бөгөөд үүнийг дахин хүчитгэсэн.

2.2.5 Газар хөдлөлт

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг нь газар хөдлөлтийн 7 баллын бүсэд хамаардаг. Баруун Баруун-Урт, Айргийн Энгэрийн алтны шороон ордын ашиглалтанд “Хүдэр-Эрдэнэ”ХХК нь ажилчдын орон сууцны болон конторын барилгад вагончик, тохижуулсан контейнеруудыг ашиглаж байна. Эдгээр нь газар хөдлөлтийн үед аюул осол багатай.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

3.1.1 Агаар орчныг хамгаалах

Тайлант онд Байгаль орчны судалгаа шинжилгээний төв болон “Ойт бүс”ХХК-тай хамтран агаарын чанарын шинжилгээ хийлгэж, дүгнэлтээр гарсан зөвлөмжийг мөрдөн ажиллаа. Хур бороо үед уурхайн ачиж буулгах талбай орчим болон уурхайн замыг 6 тн багтаамжтай усны сав бүхий чиргүүлээр зам дагуу авто машинаар чирж усалгааг хийж чийгшүүлдэг.



3.1.2 Усан орчныг хамгаалах

Тус компани нь эргэлтийн сангаас эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор ус тогтоох нуурыг байгуулан хур бороо, цасны шар усыг цуглуулан хуримтлуулж, технологид ашигладаг.

2024 онд Төслийн явцыг Баянбүрд багийн иргэдэд танилцуулж, иргэдээс гаргасан саналын дагуу тус багийн нутагт орших “Хужирын ухаа” булгийн эхийг хамгаалах ажлыг зохион байгуулж хашаалан, багийн удирдлагад хүлээлгэн өгөв.







БОАЖЯ болон Умард говийн гүвээт –Халхын дундад талын сав газрын чиглэл, удирдамжаар багийн хогийн цэгт хог хаягдлыг цэвэрлэж, ачиж зөөвөрлөсөн.





Тунаах нууруудын аюулгүй байдлыг сайжруулан шинээр хийгдсэн зураг төслийн дагуу өмнөх онуудад байгуулсан далангуудыг энэ онд үргэлжлүүлэн ашигласан.

3.1.3 Бусад хийгдсэн ажлууд

- ✓ Хотхоны ногоон бүсийг сайжруулах зорилгоор автомат усалгааны систем ашиглаж байна.
- ✓ Ус хөрсний бохирдлоос сэргийлж уурхай орчмын хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, халдваргүйжүүлэлт, ариутгалыг “Бор бураа”ХХК-иар гүйцэтгүүлж хэвшсэн.
- ✓ Ажилчдын ариун цэврийн байгууламжаас гарсан хаягдал усыг тусгай зөвшөөрөл бүхий “Ган Отгон”ХХК-аар зөөвөрлүүлдэг.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүх ажилчдаа жил бүр “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв”-д нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэгт хамруулахын зэрэгцээ ХАБ, хөдөлмөр хамгааллын чиглэлээр кабинетийн болон ажлын байран дах сургалтыг “Форум ланд” ХХК-тай хамтран тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн. Мөн “Силпро хөдөлмөр хамгаалал” ХХК-аар стандартын шаардлага хангасан ажилчдын өвөл, зуны нормын хувцасыг оёулсан.

Олборлолтын үед үүссэн тунаах нуурыг түшиглэн Баруун Баруун-Уртын хэсэгт 1 га газрыг хашаажуулан 5000 ширхэг навчит мод тарьж ургууллаа.







Олон салаа зам гарган, хөрс эвдэхээс сэргийлж, хайрга дайргаар хучилт хийж нягтруулав.







3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

2024 онд 8 га талбайд уулын ажил явуулсан ба тухайн онд 15 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 9.2 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Өмнөх жилүүдэд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай ба ажилчдын тосгон буюу хотхоны хашаанд тариалсан мод зүлгийг тогтмол усалж арчилж ирэв.

2024 онд нийгмийн хариуцлагын хүрээнд Сэргэлэн сумын дунд сургуулийн дотуур байрны багш сурагчдыг байгаль хамгаалах ажлын танилцуулга уулзалт зохион байгуулж, компанийн ажилчдын тарьж ургуулсан 160 кг орчим чацарганыг хүнсний хэрэгцээнд зориулж хандивласан. Компаний ажилчдийн гэр бүлийн хэрэглээнд 90 кг орчим чацаргана өөрсдийн талбайгаас хураан авчээ.

Мөн онд Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 5000 ширхэг навчит мод суулгах ажлыг мэргэжлийн “Бадмаараг гэрэл”ХХК-р гэрээгээр гүйцэтгүүлж, хашаалж, нийт 57 сая төгрөг зарцуулсан байна. Мод тарилтыг 5-р сард хийж, арчилж, мөн ургаагүй суулгацыг 9-р сард шинэ суулгацаар сольсон.

Төв аймгаас БОХМ-ийн төлөвлөгөөний нэмэлтээр дүйцүүлэн хамгаалах ажилд 6.4 га газрын техникийн нөхөн сэргээлтийг Баруун баруун уртын доод хэсэгт (Хунан) стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.



3.3 Нүүлгэн шилжүүлэх , нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус уурхайн эдэлбэр газар болон тусгай зөвшөөрлийн талбайд өвөлжөө, хаваржаа байрладаггүй тул 2024 онд нүүлгэн шилжүүлэх ажил хийгдээгүй болно.

3.4 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Баруун Баруун-Урт, Айргийн энгэрийн уурхайд одоогийн байдлаар түүх соёлын дурсгалт зүйл, археологи палентлогийн олдвор илрээгүй байна. Ашиглалтын явцад түүх соёлын олдвор байж болох үлдэгдэл илэрвэл олдворыг орон нутгийн байгаль орчны болон холбогдох газарт мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Дээрх менежментийн хүрээнд байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах зорилгоор техникийн ашигласан хаягдал тос, тосолгооны бүтээгдэхүүн, дугуйг “Түмэн эгшиг” ХХК-д гэрээний дагуу нийлүүлж ажиллаа.

3.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

ЗДТГ-тай зөвшилцөж орон нутагтай хамран ажиллах гэрээ, хог хаягдлын гэрээ байгуулан, хаягдал ус нийлүүлэх зөвшөөрөл авсны үндсэн дээр уурхайн хотхон, цайны газраас үүсч буй ахуйн хог хаягдлыг Сэргэлэн сумын хогийн цэгт улиралд нэг удаа хаядаг.

3.7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Тус уурхай нь Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториуд болох БОУАЯ-ны Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв УТҮГ-тай хамтран ус, хөрсний дээжийг тус тус шинжлүүлж үр дүнгээс хамаарч хур бороо бага үед усалгааг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээс гадна “Дойтын Булаг” ХХК-тай аж ахуйн гэрээ байгуулан Газрын хянан баталгаа, Байгаль орчны аудитын дүгнэлт, тайлан хийлгүүлж, өгсөн зөвлөмжийг мөрдөн ажиллаж байна. Тухайлбал ажилчдын ундны усны хэрэгцээг УБ-с “Хатан туул” ХХК-н цэвэр усаар хангадаг. Уурхайн ажилчдын ХАБ, хөдөлмөр хамгааллын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, бататгах зорилгоор кабинетийн болон үйлдвэр дээрх сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн. Үүнд “Форум ланд” ХХК-тай сүүлийн 8 жилийн хугацаанд гэрээний дагуу хамтран ажиллаж байна.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний дагуу бүх ажилчдаа жил бүр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулсан.

3.6 Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт

Тус уурхай нь байгаль орчныг хамгаалах талаарх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл тайлан болон бусад мэдээллийг нээлттэй болгож 2024 онд Төв аймгийн Сэргэлэн сумын ИТХ, ЗДТГ болон 1-р багийн багийн иргэд, малчдын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, иргэдээс гарсан саналын дагуу “Хужирын ухаа” булгийн эхийг хамгаалсан болно.

ДӨРӨВ. 2024 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

А. Хаягийн хэсэг

Байгууллагын нэр	“Хүдэр-Эрдэнэ”ХХК
Регистрийн дугаар	2041391
Нэр	Баруун Баруун-Урт, Айргийн энгэр
Код	132000
Аймаг, нийслэл	Төв
Сум, дүүрэг	Сэргэлэн
Ашигт малтмалын төрөл	Алтны шороон орд
Тусгай зөвшөөрлийн дугаар, талбай	131А, 443,0 га
Олборлох, баяжуулах технологи	Ил аргаар, тээвэртэй ашиглалтын системээр олборлоно.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн байгууллага	“ЭКОТРАСТ КОНСАЛТИНГ”ХХК
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн он	2021

Б. Уул уурхайн нөхөн сэргээлт

Үзүүлэлт				Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Хэмжээ
А				Б	В	1
1. Олборлолт эхэлсэн он				1		1994
2. Олборлолтод өртсөн талбай	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Олборлолтод өртсөн газар	Гүн	2	м	2.2
			Талбай	3	га	262.9
			Эзэлхүүн	4	мян.м ³	5783,8
		Гадаад овоолго	Гүн	5	м	-
			Талбай	6	га	-
			Эзэлхүүн	7	мян.м ³	-
		Бусад	Гүн	8	м	-
			Талбай	9	га	-
			Эзэлхүүн	10	мян.м ³	-
	Олборлолт явуулсан тайлант онд	Олборлолтод өртсөн газар	Гүн	11	м	2.2
			Талбай	12	га	15
			Эзэлхүүн	13	мян.м ³	330
		Гадаад овоолго	Гүн	14	м	-
			Талбай	15	га	-
			Эзэлхүүн	16	мян.м ³	-
		Бусад	Гүн	17	м	-
			Талбай	18	га	-
			Эзэлхүүн	19	мян.м ³	-
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Олборлолтод өртсөн газар	Гүн	20	м	1.5
			Талбай	21	га	6
			Эзэлхүүн	22	мян.м ³	90
		Гадаад овоолго	Өндөр	23	м	-
			Талбай	24	га	-
			Эзэлхүүн	25	мян.м ³	-
		Бусад	Өндөр	26	м	-
			Талбай	27	га	-
			Эзэлхүүн	28	мян.м ³	-
3. Техникийн нөхөн сэргээлт	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	29	га	154.42
			Эзэлхүүн	30	мян.м ³	772.1
		Гадаад овоолго	Талбай	31	га	-
			Эзэлхүүн	32	мян.м ³	-
		Бусад	Талбай	33	га	-
			Эзэлхүүн	34	мян.м ³	-
	Олборлолт явуулсан тайлант онд	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	35	га	15
			Эзэлхүүн	36	мян.м ³	7.5
		Гадаад овоолго	Талбай	37	га	-
			Эзэлхүүн	38	мян.м ³	-
		Бусад	Талбай	39	га	-
			Эзэлхүүн	40	мян.м ³	-
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	41	га	4
			Эзэлхүүн	42	мян.м ³	60
		Гадаад овоолго	Талбай	43	га	-
			Эзэлхүүн	44	мян.м ³	-
		Бусад	Талбай	45	га	-
			Эзэлхүүн			

**Айргийн Энгэрийн алтны шороон ордын 2024 оны
байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

			Эзэлхүүн	46	мян.м ³	-
4. Биологийн нөхөн	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	47	га	103.23
		Гадаад овоолго	Талбай	48	га	-
		Бусад	Талбай	49	га	-
	Олборлолт явуулсан тайлант онд	Биологийн нөхөн сэргээлт	Талбай	50	га	9.2
		Гадаад овоолго	Талбай	51	га	-
		Бусад	Талбай	52	га	-
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	53	га	4
		Гадаад овоолго	Талбай	54	га	-
		Бусад	Талбай	55	га	-
5. Байршуулсан нөхөн сэргээлт	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр		56	сая.төг	85.2	
	Олборлолт явуулсан тайлант онд		57	сая.төг	26.5	
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд		58	сая.төг	-	
6. Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр		59	сая.төг	390.0	
	Олборлолт явуулсан тайлант онд		60	сая.төг	56.3	
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд		61	сая.төг	40.1	
7. Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Хөрс хуулалт	Талбай	62	га	-	
		Хэмжээ	63	мян.м ³	-	
	Хүдэр олборлолт, элс угаалт	Талбай	64	га	4	
		Хэмжээ	65	мян.м ³	110	
	Бүтээгдэхүүн гаргалт		66	мян.тн		
			67	кг	3.62	
8. Олборлолтод ашиглагдах ус	Усны төрөл		68		Гүн, хур тунадас	
	Усны хэмжээ		69	мян.м ³	55	
9. Химийн хорт, аюултай бодисын	Зөвшөөрөгдсөн хэмжээ		70	кг	-	
	Зарцуулсан хэмжээ		71	кг	-	
10. Олборлолтод өртсөн ойн бүрхэвч	Талбайн хэмжээ		72	кг	-	
	Мод		73	тоо	-	

Уурхайн зөвлөх инженер..... /Ч.Энхбаяр/